

ЦЭРГИЙН БИЕЙН ТАМИРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙГ САЙЖУУЛАХАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Д.Банзрагч

ДХИС-ийн Ахлагчийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Хилийн албаны тэнхимийн ахлах багш, магистр, хошууч

Товч агуулга: Хил хамгаалах байгууллагын ахлагч бүрэлдэхүүний биеийн тамирын бэлтгэлжилтийг сайжруулах, бие бялдрын түвшинг дээшлүүлж ирсэн уламжлал, шинэчлэл, өнөө үед улсын хил хамгаалах үйл ажиллагаанд биеийн тамирын бэлтгэлжилтийг сайжруулахад тулгамдаж буй асуудлыг онол, практикийн түвшинд судалж, Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын Хил хамгаалах байгууллага, түүний харьяа хилийн анги /салбар/-т цэргийн сургалтыг зохион байгуулах үед тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдалд тохируулан сургалт явуулах, үр дүнг тооцох талаар тодорхойлохыг хичээв.

Түлхүүр үгс: Эх орон, Хил хамгаалалт, Ахлагч, Мэдлэг, үр чадвар

Оршил. Эх орныхоо ирээдүйн хувь заяаг нь тодорхойлох их үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулахаар сэтгэл шулуудан, эрдмийн моринд дөрөөлөн эх орны торгон хилд хилчин офицерийн эгнээнд алхаж чухамдаа аминаас үнэтэй эх орныхоо торгон хилийг хамгаалах, хялбархан мөртлөө хамгийн үнэ цэнэтэй байж чаддаг цорын ганц зүйл болох эрдэм мэдлэгийн үүц нөөцөө сайтар базааж тогтмол хөгжүүлэн ажиллахгүй бол оюун ухааны хатуу ширүүн өрсөлдөөний эрин зуунд ямагт ялагдсаар амьдрах болно.

Байгалийн хамгийн эмзэг, мэдрэмтгий объект болох газар нутаг, хил хязгаар хамгаалагдсан байх учиртай, үүнийг хүн төрөлхтөн өнөөг хүртэл цэрэг, армийн хүчээр хамгаалж ирсэн бөгөөд хилийн аюулгүй байдлаа хэрхэн хангасан байдлаар улс эх орны үндэсний аюулгүй байдлын баталгаа бүрэлдэн тогтож, ард иргэдийн амгалан

тайван аж төрөх бүхий л таатай нөхцөл хангагдана хэмээн үзэж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй¹⁵ Хил хамгаалах байгууллагын хилийн анги, тусгай салбар нь хилийн зурвас, бүсэд онцгой нөхцөл байдал үүсэхэд хамгийн түрүүнд уг ажиллагаатай хилчид дэр дундаа халагч бүрэлдэхүүн тулгардаг. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал COVID-19-ийн улмаас дэлхийн олон оронд тулгарч буй асуудлууд Монгол Улсад ч мөн адил бэрхшээл сорилтыг дагуулсаар байна. Энэхүү шинэ сорилт нь эдийн засаг, улс төр, нийгэм, хүмүүсийн аж төрөх хэв маягт ихээхэн өөрчлөлт нөлөө үзүүлж байна. Тухайлбал хатуу хөл хорио, “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэгт шилжсэнээр эдийн засгийн салбарт жижиг, дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсэж, Хил хамгаалах байгууллагын үйл

¹⁵ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. УБ. 2001.он

ажиллагаа, тэр дундаа цэргийн биеийн тамирын сургалт дадлага явуулхад хүндрэл үүсч үндсэндээ зогсонги байдалд орсон билээ.

Цаашид дээрх нөхцөл байдлын үед төрөл бүрийн арга хэмжээ авах нөхцөлд Хил хамгаалах байгууллагын хэмжээнд цэргийн сургалтыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулах шаардлага, ХХЕГ, хилийн цэргийн анги, хилийн цэргийн тусгай салбарт зүй ёсоор тавигдаж байна.

Гэвч хүн төрөлхтөний өмнө шийдвэрлэвэл зохих хэд хэдэн амин чухал асуудал хуримтлагдан тулгамдах болов. Хамгийн хурц асуудал нь цөмийн зэвсгийн нөөц, хуримтлал томоохон улс гүрний эдийн засгийн ашиг сонирхол, цэрэг техникийн үсрэнгүй хөгжлийн энэ цаг үед аливаа улс орон аюулгүй байдлаа хэрхэн хангаж байх, цэргийн сургалтыг хэрхэн бэлтгэж буй зарим асуудал түүнийг шийдвэрлэхийг эрмэлзэв.

Цэргийн сургалт, бэлтгэлийг зохион байгуулах үйл ажиллагааны агуулга, мөн чанар:

Хүн төрөлхтөн бүрэлдэн тогтсон өнөөгийн даяаршлын эрин зуунд оршин тогтнож буй даян дэлхийн аль ч улс орнууд өөрийн онцлогтой улсын хилтэй. Улсын хилийг олон улсын гэрээгээр төгс баталгаажуулж хамгаалдаг улсууд хөгжин цэцэглэж, ард иргэдийнхээ амгалан тайван амьдралын эх үндэс, суурь нь болдог.

Манай улсын хувьд 2100 орчим жилийн тэртээ дэлхий дахинаа анхны хилийн шугамыг тогтоон тодорхойлж, тэмдэглэн хил хамгаалах тусгайлсан чиг үүрэгтэй бүрэлдэхүүнийг бий болгож, хил залгаа улстай харилцан

тохиролцсон гэрээ хэлэлцээрийг мөрдөж байсан нь орчин үеийн улс, гүрнүүдийн хилийн аюулгүй байдлаа хангах ажиллагааны анхдагч, онол арга зүйн үндэс, түүхэн туршлага болсон билээ.

Хүний оюун ухаан урьд хожид хэзээ ч байгаагүйгээр хурдацтай хөгжиж байгаа өнөө үед хүмүүс болон хүрээлэн байгаа орчиныг хүний үйл ажиллагааны уршигаар учирч байгаа аюул занал, шинжлэх ухаан, техникийн дэвшил цөмийн болон бусад төрлийн сөнөөх чадвар бүхий зэвсэг бөөнөөр хуримтлагдсан энэ цаг үед хүн, хүн төрөлхтөний болоод улс үндэстний аюулгүй байдлыг хангахад цэргийн сургалт бэлтгэлжилт, хамгийн чухал болж буй цаг үед бид амьдарч байгаа билээ.

Хэрэв байгалийн хамгийн эмзэг, мэдрэмтгий объект болох хүн хамгаалагдсан байх учиртай юм бол байгаль, хүрээлэн байгаа орчин /цэрэг/ хамгаалалтад байх ёстой үүнийг хүн төрөлхтөн өнөөг хүртэл цэрэг, армийн хүчээр хамгаалж ирсэн бөгөөд тэр дундаа “Монгол” хэмээх улс үндэстний түүх эх дэлхий дахинд хэзээ ч дахин давтагдашгүй түүхтэй суу билэгт ард түмэн гэдгээрээ гайхагдсаар ирсэн.

Гэвч хүн төрөлхтөний өмнө шийдвэрлэвэл зохих хэд хэдэн амин чухал асуудал хуримтлагдах болов. Хамгийн хурц асуудал нь цөмийн зэвсгийн нөөц, хуримтлал томоохон улс гүрний эдийн засгийн ашиг сонирхол, цэрэг техникийн үсрэнгүй хөгжил, цэргийн бэлтгэлжилт болоод байна.

Тэгвэл энэ цаг үед Монгол улсын цэргийн хөгжил, хил хамгаалалтын анхны нэгж болох хилийн цэргийн анги, тусгай салбарын сургалт бэлтгэл

ямар түвшинд байгаа эсэх, цаашид оршин тогтнох, хилийн аюулгүй байдлаа хэрхэн хангах, цэргийн сургалт бэлтгэл хэрхэн хангагдаж буйг анхаарах цаг үе болсон гэж үзэж байна.

Аливаа улс гүрнүүд үүсч бас, устаж үгүй болсон түүхийн үйл явцыг ажиглахад “оршин тогтнох”-ын төлөөх тэмцэл нь ямар ч үндэстний **“Цэргийн бэлтгэлжилт”**-тэй, өөрөөр хэлбэл эх орноо хамгаалах бэлтгэгдсэн цэргийн хүчтэй байж, газар нутгаа хамгаалахын төлөө тэмцэж, хүчирхэгжихээрээ /Орос, Украин, АНУ, Хятад/ бусдын илүү таатай газар нутгийн хүч түрэн эзэлж, сулрахаараа бусдад эзлэгдэн хөөгдөж, зарим нь уусж устаж, тэдгээрийн хөрсөн дээр шинэ улс үндэстэн үүсч тэдгээрийн орших, эс оршихыг тодорхойлж ирсэн гол хүчин зүйл бол тухайн улс гүрний цэргийн сургалт бэлтгэлжилт юм.

Үүнтэй нэгэн адил монгол улс шинэ үндсэн хуулиа батлан, ардчилсан нийгэмд хөл тавин хөгжиж ирсэн эрс шинэчлэл өнөөг хүртэл үргэлжилж олон улсын нийтлэг эрх зүйн хэм хэмжээний хүрээнд харилцан итгэлцэл, хамтын ажиллагаанд тулгуурласан энхийг сахих, энх тайванч байдлаар зэрэгцэн орших зарчмыг хүндэтгэн өөрийн зэвсэгт хүчин, хилийн цэрэг/цэргийн хүчээр/ хамгаалах шаардлага байгаа нь аль ч улс оронд тодорхой юм.

Хүн ам, цөөн газар нутаг өргөн уудам, байгалийн баялаг, ашигт малтмал арвин, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд хөрш улс орны цэрэг-улс төрийн үсрэнгүй хөгжил ил болон далд бодлого, ашиг сонирхолын цэргийн заналхийлэл, зэвсэгт мөргөлдөөн, бүс

нутгийн тогтворгүй байдал, бий болох зэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн тогтолцоог бий болгох улмаар цэргийн аюулгүй байдлыг хангах Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг \ХХБ\ -ын оролцоо үүрэг, арга тактик, сургаж дадлагажуулах хөгжүүлэх, дэлхийн улс орны жишигт нийцэхүйц байх шаардлага тулгарч байна.,

“Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” сургалтын талаар хоёр дугаар бүлгийн 11 дүгээрт “улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх” гээд 2, 7 “хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих”² нь алба хаагчид, тэр дундаа ахлагч бүрэлдэхүүнийг тасралтгүй, орчин үеийн зэвсэг техник тоног төхөөрөмжийг улсын хил хамгаалах үйл хэрэгтэй чадварлагаар ашиглах чадвартай, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлсэн, цаашлаад нийгмийн хангамжийг сайжруулсан байна гэсэн нь бодит байдал дээр хангалттай хэмжээнд хүрэхгүй байгааг судалгаагаар харагдаж байна.

Үүнээс үзэхэд ахлагч нарын цнргийн биеийн тамрийн сургалт, бэлтгэл, албаны ур чадварыг нэмэгдүүлэх арга замыг Хил хамгаалах ерөнхий газраас бодлогын хэмжээнд авч үзэж, ахлагчийн бүрэлдэхүүнийг ахисан шатны сургууль, дамжаанд суралцуулах, төрөл мэргэжлийн ахлагч нарт хилийн албаны мэдлэг, чадвар болон цэргийн биеийн тамирын

бэлтгэлийг үе шаттайгаар сургаж, дадлагажуулах, ахлагчийн сургалт бэлтгэлийг хүн нэг бүрийн болон бүлгийн бэлтгэлээр явуулж, удирдах арга барилд сургах, сургалтын тогтолцоог шинэчлэн боловсруулах, хүн хүндээ нөлөөлөх замаар харилцааны ур чадвартай ахлагч нарыг заах арга зүйд сургах гэх мэт тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болжээ.

Дүгнэлт

Дэлхийн улс орнууд өөрсдийн түүх, туулж өнгөрүүлсэн хүнд хэцүү цаг хугацаа, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн зэргээс сургамж авч ахлагч бүрэлдэхүүний сургалтыг орхигдуулалгүй улам бүр төгөлдөржүүлсээр байна.

Хэдийгээр ахлагчийг сургаж бэлтгэх тогтолцооны эрх зүйн орчин бүрдэж байгаа хэдий ч одоо алба хааж байгаа алба хаагчдаас бодитой судалгаа авч нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, цэргийн мэргэжлийн боловсон хүчний чадавх, нөөцийг бий болгох асуудалд илүү анхаарах хэрэгтэй.

Ахлагч бэлтгэх сургалтын өнөөгийн тулгамдаж байгаа асуудлуудыг онолын хэмжээнд судлан зөвхөн сургалтын байгууллага дотооддоо сургалтыг боловсронгуй болгох биш, хилийн анги салбарууд, ХХЕГ шат шатандаа хэрэгжүүлэх боломжийг гаргаж ирэх нь чухал юм.

Ахлагч бүрэлдэхүүнийг мэдлэг, чадварыг өөрийнх нь сонирхлоор хөгжүүлэх гарц бол шат дараалсан сургалтын хөтөлбөрийг судалснаараа

мэргэжлийн зэрэг, цол хэргэм ахидаг, нээлттэй сургалтын тогтолцоо юм. Мөн тухайн ахлагч хэдийд дараагийн шатны сургалтдаа хамрагдахаа өөрийн мэдлэг чадвараас хамаарч сонгох бололцоог олгох юм. Ахлагчийг хөгжүүлэх сургалтын агуулга нь багаас ахисан төвшнөөр тасралтгүй шаталсан бүтцэд шилжиж доод шатнаасаа дээд шат хүртэл бүх сургалтууд нэг нь нөгөөгийнхөө үндэс суурь болсон байдлаар эрэмбэлэгдэн нэг бүхэл нэгдмэл тогтолцоо болон бүрэлдэж мэргэжлийн ахлагчийг бэлтгэнэ.

ХХБ-ын тулах нэгэн багана болсон ахлагч нарын боловсрол, чанар бүтээмж, өрсөлдөх чадварт онцгой анхаарч, мэргэшсэн ахлагч нараар эгнээгээ тэлж, чадамжид суурилсан хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Сургалт дамжаа дүүргэсэн ахлагч нар нь алдраа өндөрт өргөсөн төрийн албан хаагч байж, хилчдийн ёс зүйг чандлан сахисан, албан тушаалын стандартыг мөрдсөн, зорилго, тэмүүлэлтэй, байгууллагын хөгжил, хил хамгаалалтын төлөө өөрсдийн хамаарах бүхнийг чин сэтгэлээсээ хийж, өрх гэрээ өнгөлөг авч явах, эзэмшсэн мэргэжил, хариуцсан ажилдаа эзний ёсоор ханддаг, ахлагчийн манлайллыг бий болгосон ахлагч байхын төлөө хичээн зүтгэж мөрдөс дүүрэн “ахлагч”-ын алдрыг алдаршуулахад Монгол төрийн цагаан сүлд ивээх болтугай.

Ашигласан эх сурвалж

1. Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоол.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль. 2009. 3. Хил хамгаалах байгууллагын “Хүний нөөцийн дүрэм”. 2009.

3. ХХБ-ын ахлагч бүрэлдэхүүний стандарт

4. ХХБ-ын ахлагч бүрэлдэхүүний хүрсэн байх түвшин /стандарт/

5. Цэргийн биеийн тамир бэлтгэлжилтийн стандарт